


ШИВЭЭ ОВОО ХК

# 2021 ОНЫ ТАЙЛАН

ШИВЭЭ ОВОО ХК

# МЭНДЧИЛГЭЭ

## “ШИВЭЭ-ОВОО” ХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

# Ц.ЭНХТҮВШИН




Хүндэт хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээ

Та бүхний амрыг эрин мэндчилж “Шивээ-овоо” хувьцаат компанийн 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлыг тайлагнаж байна.

Шивээ Овоогийн уурхай нь жилдээ дунжаар 8.6 сая.м3 хөрс хуулж, 2.0 сая.тн нүүрс олборлон, борлуулах хүчин чадалтай ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн ЭБМЗ-ийн хурлаар, улсын төвийн эрчим хүч, дулааны хэрэглээний өсөлтийг үндэслэн 4.5 сая тн нүүрс олборлох ТЭЗҮ-г хэлэлцүүлж 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан билээ.

Шивээ Овоогийн ордын нүүрс нь Х-3 бүлгийн хүрэн нүүрсний ангилалд хамаарах ба одоогийн байдлаар Монгол улсын дотоодын эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 28.3%, “ДЦС-4” ТӨХК-ийн хэрэгцээний 50.0%-ийг дангаараа хангаж, Говьсүмбэр, Дорноговь, Сэлэнгэ, Төв аймаг болон бусад дотоодын аж ахуй нэгжүүдийн дулаан, цахилгааны станцуудад нүүрс нийлүүлж ажиллалаа.

2020-2021 онд Монгол улсын Сангийн яам “JBIC"-ийн зээлийн хүрээнд хийгдсэн технологийн автомашин, гидроэкскаваторын шинэчлэлийн хүрээнд техникийн найдвартай ажиллагаа тогтворжиж байна.

2021 онд “ДЦС-IV” ТӨХК болон бусад нүүрс хэрэглэгч байгууллагуудын 1,963.1 мян.тн нүүрсийг захиалгын дагуу нийлүүлэх ажлын хүрээнд 1980.0 мян.тн нүүрс олборлон нийлүүлж, 8,703.5 мян.м3 хөрс хуулах, үүнээс тээвэртэй 6,455.0 мян.м3, тээвэргүй 2,248.5 мян.м3-ын төлөвлөгөөтэй ажилласан.

Уулын ажлын гүйцэтгэлээр нүүрс олборлолт 2,040.2 мян.тн, борлуулалт 2,049.8 мян.тн, нийт хөрс 9,374.0 мян.м3 үүнээс тээвэртэй 7,048.9 мян.м3, тээвэргүй 2,325.1 мян.м3 хөрсний ажил тус тус гүйцэтгэж, төлөвлөгөөг 101.6-108.0 хувь биелүүлсэн байна.

Уурхай 2.0 сая.тн нүүрс олборлох төслийн хүчин чадлаа эзэмшсэнээс хойш уулын ажлын дээд үзүүлэлтүүдээ энэ онд шинэчлэн тогтоосон бөгөөд “ДЦС-IV” ТӨХК-д 1992 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 30 жилийн хугацаанд 30.0 сая.тн нүүрс нийлүүлсэн түүхэн үйл явдал тохиосон байна.

Нүүрс шинжилгээний лаборатори нь 2021 оны 6-р сараас ISO/IEC 170025:2018 стандартын шаардлага хангаж, нүүрсний чанарын итгэмжлэгдсэн үзүүлэлтүүдийг тодорхойлон ажиллаж байна.

Уул ажлын төлөвлөлт зураглалтын “CARLSON MINING” программийг нэвтрүүлэн нутагшуулахаар ажиллаж байгаа бөгөөд маркшейдерийн хэмжилтийн ажлыг агаарын зураглалын дроноор гүйцэтгэж байгаа нь хэмжилт, статистикийн зөрүүг 27%-иар бууруулж, уулын ажлын ахилтын хэмжилтийг өндөр нарийвчлалтай гаргахын зэрэгцээ уурхайн цаашдын төлөвлөлт, тооцоолол боловсруулах ажилд дэвшил авчраад байна.

Жилийн эцсийн байдлаар складанд 45.2 мян.тн, карьерт авахад бэлэн 50.0 мян.тн, нээгдэхэд бэлэн 100.0 мян.тн нүүрний нөөцтэй шилжсэн.

Нүүрс борлуулалтын өссөн захиалгыг хангахын тулд төлөвлөгөөнөөс 265.0 мян.м3 хөрс илүү хуулсан ба ажлын бүтээмж, цаг ашиглалтыг нэмэгдүүлснээр оны эцэст урьд онуудад үүссэн уурхайн нийт хөрсний хоцрогдлыг 405.5 мян.м3-ээр бууруулсан.

2011 оноос хойш үүссэн хамгийн их тээвэртэй хөрс хуулалтын хоцрогдолтой талбайд “ЭШ 25/90” алхагч экскаваторын ажлын фронтыг бэлтгэсэн ба “ЭКГ-5А” цахилгаан экскаватораар ажлын бус талын өмнөх онуудад нүүрс олборлосон хоосон орон зайд хөрсний шидэлт хийлгэн тээврийн зам засаж ажилласан нь тээвэргүй хөрс хуулалтын төлөвлөгөөг давуулан биелүүлэх үндэслэл болсон.

“Шивээ-Овоо” ХК-ийн зүгээс /MV-000901, MV-013311, MV-013312/ талбайнуудад нарийвчилсан хайгуул хийлгэх ажлын саналыг “ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-д удаа дараа хүргүүлснээр “JORC” стандартад нийцсэн хайгуулын ажлыг 3-н үе шаттайгаар гүйцэтгэх шийдвэр гарсан болно.

Хяналтын цооногуудын мэдээллээр карьерийн усны түвшинг 3.58 м буулгасан ба карьерт нүүрс олборлолтын ажил гүйцэтгэсэн ашиглалтын 2 дугаар аманд ил зумпфын аргаар насос байрлуулан усны түвшинг 17 м-ээр буулган устай 650.0 мян тн, нийт 730.0 мян тн нүүрсийг усны хүндрэлгүй бүрэн олборлож чадсан.

Техникийн шинэчлэлийн хүрээнд “Комацу” брендийн 5,2 м3 шанагатай “PC-1250” маркийн гидроэкскаватор 2 ш, ”Dump truck HD 465” ТАМ – 5 ш, “HYUNDAI” брендийн “D6HA” маркын гал унтраах машин 1 ширхэг зэрэг тоног төхөөрөмжүүдээр хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

2021 онд 2,049.8 мянган тонн нүүрс борлуулж нүүрс борлуулалтын төлөвлөгөөг 3.6 хувь буюу 76.2 мянган тонноор дутуу гүйцэтгэсэн байна. 2021 онд борлуулалтаас 60382.3 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 59,347.9 сая төгрөгийн орлого олж 98.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Вагон ачилтын 10-р салаа төмөр замыг өргөтгөж, нэг удаагийн тавилтаар 16 вагон ачих боломжтой боллоо.Биологийн нөхөн сэргээлт хийгдсэн 13 га талбайг улсын комисст хүлээлгэн өгсөн ажил хийгдлээ.

Шивээ-Овоо” ХК-ийн хамт олон бид дэлхий нийтээр цар тахал нүүрлэсэн энэ цаг үед санхүү,эдийн засгийн хямралтай хүнд байдлыг даван туулж, эх орныхоо гал голомтыг эрчим хүч, нүүрсээр таслахгүйн төлөө хичээнгүйлэн 1 өдөр ч зогсохгүй ажиллаж байна. Мөн олон мянган хэрэглэгчдийнхээ эрх ашгийг дээдлэн, нүүрсээр тасралтгүй найдвартай хангах үүргээ уурхайчид бид нэр төртэй биелүүлж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

# АГУУЛГА


1. Товч танилцуулга

2. Компанийн бүтэц, зохион байгуулалт

3. 2021 оны уулын ажлын төлөвлөгөөний биелэлт

4. Гүний усны шүүрүүлэлтийн байдал

5. Өрөмдлөг, тэсэлгээний ажлын талаар

6. Техник тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал

7. 2021 онд хөрөнгө оруулалтаар авсан техникүүд

8. Компанийн техник эдийн засгийн нэгдсэн үзүүлэлт

9. Компанийн удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн талаар

10. ХАБ Эрүүл ахуй

11. Техникийн нөхөн сэргээлт

12. ТУЗ-ийн тайлан

13. Санхүүгийн тайлан




»ШИВЭЭ-ОВОО» ХК

# ТҮҮХЭН ТОВЧООН




Улсын төсвийн хөрөнгөөр Шивээ-Овоогийн нүүрсний ордод урьдчилсан болон нарийвчилсан хайгуул хийж 1989 оны 12-р сарын 22-ны өдрийн Улсын нөөцийн комиссийн 33-р тогтоолоор ордын геологийн нөөцийг нь тогтоосон.

ЭХУУҮГЯ-наас Налайх дахь Уурхайн барилга трестийн харъяанд Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг байгуулах шийдвэр гарч монгол инженерүүдийн ур чадвараар бүтээн байгуулагдаж 1992 онд нүүрс олборлон эхэлсэн.

1995 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурлаар тус уурхайг Төрийн өмч давамгайлсан "Шивээ-Овоо" ХК болгон өөрчлөн зохион байгуулж, компанийн дүрмийн сангийн 90% нь төрийн өмчид үлдэж, 10% нь 1631 гаруй хувьцаа эзэмшигчдэд хувьчлагдсан байна.

Нүүрсний салбарыг хөгжүүлэх "Мастер төлөвлөгөө"-ний хүрээнд 1998 онд Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр уурхайн техник, технологийг шинэчлэх төсөл хэрэгжиж эхэлсэн.

2004 оны 09 сарын 11-ний өдөр 1.0 сая дахь тонн нүүрсээ олборлож 10 сарын 14-ны өдөр 1.0 сая тонн нүүрсээ борлуулсан.

"Мастер төлөвлөгөө" 2 дахь төслийн ажлыг 2007 оны сүүлчээр дуусгаж жилдээ 4.6 сая шоо метр хөрс хуулж, 2.2 сая тонн нүүрс олборлох борлуулах боломж бүрдсэнээр хүчин чадал нь 4 дахин нэмэгдсэн.

2017 онд 2,020,280.0 тонн нүүрс борлуулж түүхэн дээд амжилт тогтоосон. Хүн тээврийн автобус 2 ш, Зам усалгааны автомашин 1ш, Түлшний цистерн 1ш, Суудлын автомашин 1ш тус тус худалдан авсан.

Засгийн газрын 132 дугаар тогтоол гарч Мон П4 болон Мон П5 зээлийг тухайн уурхайд оруулсан хөрөнгө оруулалт болгон тооцох асуудлыг шийдвэрлэсэн.

Автогрейдер 1ш, Бульдозер 2ш, Дугуйт ачигч 1ш, CAT773E технологийн автомашин 2ш, Үйлчилгээний автомашин 1ш, Хүн тээврийн автобус 2 ш, Бутлуур шигшүүр /зөөврийн/ 1ш, Хийн компрессор 1ш тус тус худалдан авсан.

305 айлын орон сууцыг ажилчидадаа хөнгөлөлттэй үнээр хувьчлав. MV-000901, MV-013311, MV-013312 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий ордын Шинэ-Усны хэсгийг жилд 4.5 сая.тн олборлон, борлуулах ТЭЗҮ-ийг боловсруулж, 2019.01.15-ны өдөр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн 2019.05.13-нд УУХҮЯ-аар батлуулж 2019.12.31-ны өдөр Уурхайг улсын комисст хүлээлгэн өгсөн.

Урал хүн тээврийн автобус 2ш
Үйлчилгээний автомашин 3ш
Komatsy-HD465-7R технологийн автомашин 5ш
Komatsy-PC1250 гидро экскаватор 2ш
TEREX TR60W усны машин 1ш тус тус худалдан авсан

Комацу брендийн 5,2 м3 шанагатай PC-1250 маркийн гидроэкскаватор 2, Dump truck HD 465 – 5 ш, HYUNDAI брендийн D6HA маркын гал унтраах машин 1 ширхэг зэрэг тоног төхөөрөмжүүдээр хөрөнгө оруулалтыг хийсэн.

12-р сарын 25-ны өдөр "ДЦС-IV" ТӨХК-д 30-н жил 30.0 сая.тн, 2045.0 мян.тн

# Компанийн бүтэц, зохион байгуулалт

ШИВЭЭ ОВОО ХК

“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2022 ОНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ




ШОХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 31-ны 18 тоот тогтоолын 4-р хавсралт, Гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/08 дугаар тушаалаар “Компанийн бүтэц, орон тоо”-нд өөрчлөлт оруулж, компанийн удирдлага зохион байгуулалтын бүтцийг 5 хэлтэс, 4 алба, 7 хэсэг, 1 охин компани, ажиллах хүчний орон тоо 487 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулахаар шинэчлэн баталсан.

# Уулын ажлын төлөвлөгөөний биелэлт

ШИВЭЭ ОВОО ХК

| А.Уулын ажлын үзүүлэлт | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Д.д | Үзүүлэлтүүд | Хэм.нэгж | 2016 оны гүйцэтгэл | 2017 оны гүйцэтгэл | 2018 оны гүйцэтгэл | 2019 оны гүйцэтгэл | 2020 оны гүйцэтгэл | 2021 он | | 2022 оны гүйцэтгэл |
| | | | | | | | | төлөвлөгөө | гүйцэтгэл | |
| 1 | Нүүрс олборлолт | м.тн | 1,961.4 | 2,037.0 | 2,000.7 | 1,992.3 | 2,007.3 | 1,980.0 | 2,040.2 | 2,000.0 |
| **2** | **Нүүрс борлуулалт** | **м.тн** | **1,880.9** | **2,020.3** | **1,964.3** | **2,009.8** | **1,988.5** | **1,963.1** | **2,049.8** | **2,000.0** |
| 3 | Тээвэртэй хөрс хуулалт | м.м³ | 5,427.7 | 5,360.3 | 4,915.6 | 6,237.6 | 5,621.5 | 6,455.0 | 6,934.3 | 6,365.0 |
| 4 | Тээвэргүй хөрс хуулалт | м.м³ | 1,786.8 | 1,834.2 | 2,049.7 | 2,336.0 | 2,220.0 | 2,248.5 | 2,439.7 | 2,100.0 |
| 5 | Дахин шидэлт | м.м³ | 2,033.7 | 3,229.5 | 1,810.7 | 2,470.7 | 3,342.4 | 2,818.5 | 2,489.7 | 2,850.0 |
| **6** | **Нийт хөрс хуулалт** | **м.м³** | **7,214.5** | **7,194.6** | **6,965.3** | **8,573.6** | **7,841.5** | **8,703.5** | **9,374.0** | **8,465.0** |
| 7 | Инженер ажил | м.м³ | 663.4 | 1,047.7 | 595.0 | 768.9 | 490.1 | 747.9 | 855.8 | 765.0 |
| **8** | **Нийт уулын цул** | **м.м³** | **11,532.6** | **13,155.2** | **11,024.5** | **13,459.7** | **13,333.0** | **13,906.3** | **14,405.6** | **13,732.9** |

**2020 он**



**2021 он**



**2022 он**



Shivee-ovoo.mn

# 2021 оны уулын ажлын төлөвлөгөөний биелэлт

ШИВЭЭ ОВОО ХК












# Гүний ус шүүрүүлэлтийн байдал

ШИВЭЭ ОВОО ХК

Уурхайн үйл ажиллагааг саадгүй явуулахын тулд гүний усны түвшинг нүүрсний давхаргаас доош барих шаардлагатай бөгөөд уурхайн гүн гүнзгийрэх тусам гүний усыг зайлуулахад хүндрэл гарч байна.
Ус шүүрүүлэх нь 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар A, B, C, 16, D шугам болон карьерийн ЦНС насосууд жилийн дунджаар нийт 37 худаг ажиллаж, 3387.9 мян.м3 ус уурхайгаас зайлуулахаар төлөвлөснөөс нийт 34 худаг ажиллаж 92.0 %-тай, 2952.3 мян.м3 ус уурхайгаас зайлуулж биелэлт 87.1 %-ийн гүйцэтгэлтэй ажилласан. Хяналтын цооногуудын дунджаар оны эхнээс 1127.79м – 1125.87м түвшинд -1.92 м-ээр буурсан байна.

2021 оны ус шүүрүүлэхийн төлөвлөгөөнд ашиглалтын D24, D25, D26, D41, D42, D43, D44, хяналт №12 дугаартай 8 ширхэг цооног 1568 уртааш метр өрөмдөж монтажлан ашиглалтад оруулахаас ашиглалтын D24, D25, D26, дугаартай 3 ширхэг цооног 492 уртааш метр, хяналтын №12 дугаартай 1 ш цооног 180 уртааш метр нийт 672 уртааш метр өрөмдөж монтажлан ашиглалтад оруулсан. D24, D25, D26-р худгийн салбар шугамын 4.0 мян.м3 хөрсөөр далан байгуулан шугам хоолойн хучилт хийж хэлбэршүүлсэн.
Хяналтын цооногуудын мэдээллээр карьерийн усны түвшинг 3.58 м буулгасан ба карьерт нүүрс олборлолтын ажил гүйцэтгэсэн ашиглалтын 2-р аманд ил зумпфын аргаар насос байрлуулан усны түвшинг 17 м-ээр буулган, нийт 730.0 мян тн нүүрсийг усны хүндрэлгүй бүрэн олборлож чадсан.



# Өрөмдлөг, тэсэлгээний ажлын талаар

ШИВЭЭ ОВОО ХК

2021 онд нийт 2,382.2 тн энгийн тэсрэх бодис, 168.0 тн эмульсийн тэсрэх бодис зарцуулж, 201.9 мян.у.м өрөмдөн 6,429.8 мян.м$^3$ уулын цулыг тэсэлж сийрэгжүүлэхээр төлөвлөсөн.

2021 оны гүйцэтгэлээр 19,371 ширхэг цооногийг 160.5 мян.м у/метр өрөмдөж 6,285.6 мян.м$^3$ уулын цулыг 116.3 тн эмульсын тэсрэх бодис, 1,954.8 тн энгийн найрлагат тэсрэх бодис зарцуулан 382 удаагийн тэсэлгээгээр тэсэлж сийрэгжүүлсэн байна.

| Үзүүлэлт | Уулын цул /мян.м3/ | | | Уртааш метр /мян.м/ | | | ЭНТБ /тн/ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| Тээвэргүй хөрс | 1307.1 | 1529.4 | 222.3 | 31.1 | 32.41 | 1.31 | 496.7 | 483.16 | -13.5 |
| Тээвэртэй хөрс | 3977.3 | 3917.8 | -59.5 | 119.8 | 105.27 | -14.53 | 1450.2 | 1261.84 | -188.4 |
| Нүүрс гаргалт | 1145.45 | 738.35 | -407.1 | 50.9 | 22.78 | -28.12 | 435.3 | 209.75 | -225.6 |
| Нийт | 6429.8 | 6185.5 | -244.3 | 201.9 | 160.46 | -41.34 | 2382.2 | 1954.76 | 427.5 |

# Техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал

ШИВЭЭ ОВОО ХК

Уурхайн хэмжээнд 2021 оны байдлаар нийт 42 нэгж машин механизм, техникүүд ТББК-0.76%, ТАК-0,72% байна.







| Д.д | Нэрс | Машин механизмын тоо | Ашигласан жил |
|---|---|---|---|
| 1 | CAT773D технологийн автомашин | 1 | 11 жил |
| 2 | CAT773E технологийн автомашин | 6 | 3-аас 4 жил |
| 3 | HD465-7R технологийн автомашин | 5 | 1жил |
| 4 | БелА375137-7555E | 4 | 6 жил |
| 5 | Түрэх механизм | 6 | 2-оос 10 жил |
| 6 | Ухаж ачих механизм | 7 | 3-аас 10 жил |
| 7 | Зам усалгааны машин | 2 | 2жил, 19жил |
| 8 | ЭШ 25/90 алхагч экскаватор | 1 | 17 жил |
| 9 | ЭШ 11/70 алхагч экскаватор | 1 | 6 жил |
| 10 | ЭКГ 10И экскаватор | 1 | 4 жил |
| 11 | ЭКГ5А экскаватор | 4 | 16-29 жил |
| 12 | Тэсэлгээний өрөм | 2 | 21жил, 2жил |
| 13 | Хайгуулийн өрөмдлөгийн машин | 1 | 6 жил |
| 14 | Өрөмдлөгийн машин | 1 | 8 жил |
| | Нийт | 42 | |

| Машин, техник | 2020 оны жилийн дундаж | | 2021 оны жилийн дундаж | |
|---|---|---|---|---|
| Нэр | ТББК | ТАК | ТББК | ТАК |
| Технологийн автомашин | 0.73 | 0.72 | 0.80 | 0.78 |
| Хүнд машин механизм | 0.65 | 0.64 | 0.69 | 0.66 |
| Өрмийн машин | 0.80 | 0.80 | 0.55 | 0.54 |
| Цахилгаан экскаватор | 0.94 | 0.74 | 0.91 | 0.72 |
| Алхагч экскаватор | 0.80 | 0.79 | 0.89 | 0.85 |
| ДҮН | 0.72 | 0.68 | 0.76 | 0.72 |

Өнөөгийн байдлаар ашиглалтын норм гүйцсэн 15 ширхэг техник ашиглагдаж байна. Энэ нь нийт техникийн 35% юм.










# ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ

ШИВЭЭ ОВОО ХК




Үе дамжсан уурхайчдыг бий болгох, хүний нөөцийг тогтвор суурьшилтай байлгах бодлого хэрэгжиж байгаагийн үр дүн юм.

Мөн тус компанид 72 гэр бүлийн 144 ажилтан ажиллаж байна.






ГҮЙЦЭТГЭХ АЖИЛТАН



ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЖИЛТАН



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН



520 АЖИЛТАН

ҮНДСЭН АЖЛЫН БАЙР **484**

ХӨЛСӨӨР АЖИЛЛАХ ГЭРЭЭ **22**

ХҮҮХЭД АСРАХ ЧӨЛӨӨТЭЙ **14**



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

## ХҮНИЙ НӨӨЦИЙН СТАТИСТИК

### БОЛОВСРОЛ



- 186-36% ДЭЭД
- 280-54% МБТ
- 22-4% БҮРЭН ДУНД
- 22-4% СУУРЬ БОЛОВСРОЛ
- 4-1% БАГА
- 6-1% БОЛОВСРОЛГҮЙ

### НАС



- 18-35 НАСНЫ 48%
- 36-45 НАСНЫ 32%
- 46-60 НАСНЫ 20%

### АЖИЛЛАСАН ЖИЛ



- 0-10 ЖИЛ 67%
- 11-20 ЖИЛ 29%
- 21-С ДЭЭШ ЖИЛ 4%

# 2021 оны хөрөнгө оруулалтаар авсан техникүүд

ШИВЭЭ ОВОО ХК



**Коматцу-465**
**5 ширхэг**
9.0 тэрбум төгрөг, үүнээс 4.2 тэрбум төгрөг төлж 4.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй
Гэрээнд заасан хувиарын дагуу төлбөр төлбөр төлөгдөж байгаа

**Гидроэкскаватор-1250,**
**2 ширхэг**
5.7 тэрбум төгрөг, үүнээс 1.2 тэрбум төгрөг төлж, 4.4 тэрбум төгрөгний үлдэгдэлтэй
Гэрээнд заасан хувиарын дагуу төлбөр төлбөр төлөгдөж байгаа





**ГАЛЫН МАШИН**
**1 ширхэг**
21.7 сая төгрөг
Бүрэн төлөгдсөн

# Компанийн техник-эдийн засгийн нэгдсэн үзүүлэлт

| Д/д | Үзүүлэлтүүд | Хэм нэгж | 2020 оны гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төл-тэй | Өнгөрсөн онтой |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **I Эдийн засгийн үзүүлэлт** | | | | | | |
| 1 | Нүүрс олборлолт | м.тн | 2,007.0 | 1,980.0 | 2,040.2 | 103.0 | 101.7 |
| | Нүүрс борлуулалт | м.тн | 1,988.6 | 1,963.1 | **2,049.8** | 104.4 | 103.1 |
| | Хөрс хуулалт | м.м³ | 7,841.6 | 8,703.5 | **9,374.0** | 107.7 | 119.5 |
| | Нийт уулын цул | м.м³ | 13,333.0 | 13,906.2 | **14,405.6** | 103.6 | 108.0 |
| 2 | **Нийт орлого:** | **м.төг** | **57,892,474.6** | **60,598,968** | **59,588,791.9** | 98.3 | 102.9 |
| | Үүнээс Цэвэр борлуулалт | м.төг | 57,710,409.3 | 60,382,328 | 59,347,899.6 | 98.3 | 102.8 |
| 3 | **Нийт зардал:** | **м.төг** | **60,196,778.3** | **65,170,493.8** | **68,210,954.9** | 104.7 | 113.3 |
| | Үүнээс:Удирдлагын | м.төг | 748,510.8 | 491,878 | 432,606.0 | 87.9 | 57.8 |
| | **Нийт өртөг** | м.төг | **60,196,778.3** | **65,170,493.8** | **68,210,954.9** | 104.7 | 113.3 |
| **4** | **Татварын өмнөх ашиг(алдагдал)** | **м.төг** | **(2,304,303.7)** | **(4,571,525.7)** | **(8,623,640.6)** | 188.6 | 374.2 |
| 5 | Төсвийн төлбөрт: | м.төг | 9,557,964.3 | 10,654,973.6 | 9,783,891.7 | 91.8 | 102.4 |
| | Үүнээс: а\ Орлогын татварт | м.төг | 408.6 | - | 1,086.5 | 0.0 | 265.9 |
| | б\ НӨАТ | м.төг | 5,771,040.9 | 6,523,326.8 | 5,934,790.0 | 91.0 | 102.8 |
| | в\ Бусад татварт | м.төг | 3,786,514.8 | 4,131,646.8 | 3,848,015.2 | 93.1 | 101.6 |
| 6 | Нийт авлага | м.төг | 2,843,249.5 | 2,910,234.5 | 6,267,059.1 | 215.3 | 220.4 |
| 7 | **Нийт өглөг** | м.төг | 127,713,400.9 | 127,456,604.9 | 133,926,323.7 | 105.1 | 104.9 |
| | Үүнээс богино хугацаат өглөг | м.төг | 52,210,488.0 | 51,163,998 | 49,455,505 | 96.7 | 94.7 |
| 8 | Сарын дундаж цалин | м.төг | 1,446.7 | 1,252.6 | 1,378.7 | 110.1 | 95.3 |
| 9 | 1 тн нүүрсний өртөг | төг | 31,228.0 | 32,250.0 | 32,421.3 | 100.5 | 103.8 |
| 10 | 1 тн нүүрсний дундаж үнэ | төг | 29,021.1 | 30,758.8 | 28,953.1 | 94.1 | 99.8 |
| 11 | 1 м³ уулын цулын өртөг | төг | 4,396.0 | 4,591.8 | 4,588.2 | 99.9 | 104.4 |
| 12 | Нийт цалингийн сан | м.төг | 12,798,472.7 | 13,262,942.0 | 12,988,697.9 | 97.9 | 101.5 |
| 13 | Ажилчдын тоо | хүн | 559.0 | 582.0 | 526.0 | 90.4 | 94.1 |
| 14 | Бор-ын 1 төг-т ногдох зардал | төг | 1.0 | 1.1 | 1.1 | 105.2 | 111.4 |
| 15 | Хөдөлмөрийн бүтээмж орлогоор | м.төг | 103,238.7 | 104,121.9 | 113,191.62 | 108.7 | 109.6 |
| 16 | Хөдөлмөрийн бүтээмж ажлаар | м.м3 | 23.9 | 23.9 | 27.39 | 114.6 | 114.6 |
| | **II Түлш эрчим хүчний найдвартай байдал** | | | | | | |
| 1 | Аваар, осол /техникийн/ | тоо | - | - | - | 0.0 | 0.0 |
| 2 | Хөрс хуулалтын коэффициент | м³/тн | 3.9 | 4.4 | 4.6 | 104.5 | 117.8 |
| 3 | Ус шүүрүүлэлт | м.куб | 2,632.1 | 3,388.0 | 2,952.3 | 87.1 | 112.2 |
| 4 | Нөхөн сэргээлтийн зардал | м.төг | 49,580.0 | 125,000.0 | 16,400.0 | 13.1 | 33.1 |




- 1 тонн нүүрсний үнийг 2019 оны 7 сарын 9-ний өдрөөс 2000 төгрөгөөр нэмэгдүүлж **29,060.00** төгрөг болгосон.
- 2021 оны 12 сарын 31-ны байдлаар 1 тн нүүрсний бодит өртөг **32421** төгрөг байна.

| | | | |
|---|---|---|---|
| 1. | "ДЦС"-4 ТӨХК | 29,060.00 | Эрчим хүчний зохицуулах хоро |
| 2. | Бусад хэрэглэгч | 29,060.00 | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 3. | Гадны тээвэр | 30,380.00 | Төлөөлөн удирдах зөвлөл |

# 2021 онд авсан зээлийн мэдээлэл

ШИВЭЭ ОВОО ХК

ШИВЭЭ ОВОО

JBIC

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

JBIC төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний төлбөр 2021 онд 11.8 тэрбум байснаас 2.6 тэрбум төгрөг төлөгдсөн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 4 сарын 20-ний өдрийн 9 тоот тогтоолын дагуу арилжааны банк буюу “Голомт” банкнаас 5.0 тэрбум төгрөгийн зээлийг авч Татвар, НДШ, шатахуун, “JBIC” төслийн төлбөрт зарцуулсан болно.

Арилжааны банкнаас 5.0 тэрбум төгрөг авсан.
/Хугацаандаа төлөгдөж дууссан/

# Авлагын бүтэц




## Нүүрсний авлагын задаргаа

| Дд. | Харилцагчийн нэр | 2020.12.31 | 2021.12.31 |
|---|---|---|---|
| 1 | Улаанбаатар ТЭЦ-4 | 666,877.30 | 1,356,133.00 |
| 2 | Амгалан ДСтанц ХХК | 473,821.10 | - |
| 3 | Налайх дулааны станц | 223,000.00 | 54,955.80 |
| 4 | Чандмань илч Дорноговь | 89,000.00 | 319,588.30 |
| 5 | Хөтөл Цемент шохойн хк | 568,000.00 | 450,000.00 |
| 6 | Хөтөл энержи дулаан ХХК | 525,000.00 | 535,000.00 |
| 7 | Сэлэнгэ Энерго ОНӨҮГазар | 775,807.90 | 745,235.30 |
| 8 | Бор Өндөрийн үйлдвэр УБҮ | 206,566.60 | 125,634.20 |
| 9 | Үнэн Мөнх Би Эл Ди ХХК | 30,800.00 | 19,500.00 |
| 10 | Сэлэнгэ тэнгэр хараа ХХК | 342,321.90 | 342,321.90 |
| 11 | Энержиплас ХХК | 343,346.50 | 589,727.00 |
| 12 | Бусад /Нүүрс/ | 827,133.30 | 627,280.60 |
| | **Дүн** | **5,071,674.60** | **5,165,376.10** |
| | **Шүүхийн шийдвэртэй ч хэрэгждэггүй авлага** | | |
| 1 | Энэрэлт Ээж ХХК | 248,815.60 | 248,815.60 |
| 2 | Ханын материал Холд | 44,087.30 | 44,087.30 |
| 3 | Квартит ХХК | 17,196.80 | 17,196.80 |
| 4 | Сэлэнгэ гурванбулаг ХХК | 10,000.00 | 10,000.00 |
| | **Дүн** | **320,099.70** | **320,099.70** |
| | **Нүүрсний авлагын дүн** | **5,391,774.30** | **5,485,475.80** |
| 1 | Байгууллагаас авах авлага | 279,228.50 | 296,178.10 |
| 2 | Ажилчдаас авах авлага | 57,883.90 | 23,718.80 |
| 3 | Хувь хүмүүсээс авах авлага | 84,439.50 | 73,471.80 |
| 4 | Бусад тооцооны авлага | 130,770.20 | 130,770.20 |
| 5 | Байрны авлага | 87,765.90 | 74,791.80 |
| 6 | Бусад авлага | - | 182,652.60 |
| | **Дүн** | **640,088.00** | **781,583.30** |
| | **Нийт авлагын дүн** | **6,031,862.30** | **6,267,059.10** |

# Өглөгийн бүтэц

ШИВЭЭ ОВОО ХК

## АВЛАГА




## Өглөгийн задаргаа

| Зээлийн утга | | 31/12/2020 | 31/12/2021 |
|---|---|---|---|
| Урт хугацаат | ЗГ-н урт хугацаат зээл /MONP4/ | 22,518,606.30 | 22,518,606.30 |
| | ЗГ-н урт хугацаат зээл /MONP5/ | 36,677,271.90 | 36,677,271.90 |
| | ЗГ-н урт хугацаат зээл /MONP4,5тохируулга/ | 2,839,665.90 | 3,082,485.30 |
| | Сангийн яам зээл /JIBC / | - | **9,228,478.80** |
| | Юнайтед Белаз Машинери ХХК | 12,409,553.70 | 12,244,553.70 |
| | Хойшлогдсон татварын өглөг | 358,564.60 | - |
| | Ажилчдын тэтгэврийн сан | 940,762.60 | 719,422.60 |
| **Урт хугацаат өглөгийн дүн** | | **75,744,425.00** | **84,470,818.60** |
| Богино хугацаат | MONP4,MONP5 зээлийн хүүгийн өглөг /Сангийн яам/ | 7,303,638.30 | 7,977,932.10 |
| | Эрдэнэс Монгол ХХК-ийн зээл | 5,458,315.10 | 4,458,315.10 |
| | Эрдэнэс Монгол ХХК-ийн зээлийн хүү | 668,999.50 | 1,041,885.40 |
| | Эрдэнэс Монгол ХХК-ийн менежментийн төлбөр | 3,790,317.90 | 4,550,191.70 |
| | Эрдэнэс Монгол ХХК-ийн талбай ашиглалтын төлбөр | 1,956,550.00 | 2,203,390.00 |
| | Эрдэнэс Монгол ХХК-ийн ХХСангийн төлбөр | 4,021,827.10 | 4,021,827.10 |
| | Эрдэнэс Монгол ХХК-ийн /аудит, ногдол ашиг/ | 221,777.20 | 221,777.20 |
| | Санхүүгийн түрээс ДБМ лизинг | 936,881.90 | 807,112.90 |
| | Байгууллагуудын өглөг | 7,594,290.90 | 6,675,080.10 |
| | Татварын өглөг | 10,129,621.90 | 8,514,981.80 |
| | НДШ-ийн өглөг | 5,508,113.90 | 5,626,833.30 |
| | Цалингийн өглөг | 971,585.70 | 1,525,918.00 |
| | Ногдол ашгийн өглөг | 13,041.90 | 13,041.90 |
| | Урьдчилж орсон орлого | 17,218.50 | 17,218.50 |
| | Богино хугацаат зээл /Голомт/ | 3,620,000.00 | 1,800,000.00 |
| **Богино хугацаат өглөгийн дүн** | | **52,212,179.80** | **49,455,505.10** |
| **Нийт өглөгийн дүн** | | **127,956,604.80** | **133,926,323.70** |

# “ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ШИВЭЭ ОВОО ХК

## “ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

| | | |
|---|---|---|
| **1** | **С.Бүрэнбат** | **“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга** |
| 2 | Д.Чимэддорж | “Шивээ Энержи” эрчим хүчний экспортын төслийн зөвлөх |
| 3 | Б.Тэлмүүн | Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын төсвийн орлогын хэлтсийн дарга |
| 4 | Д.Болор-Эрдэнэ | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиргаа, зохион байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| 5 | Д.Дамба | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ахлах шинжээч |
| 6 | Д.Даянбилгүүн | “БиДиСек” ХК-ийн Гүйцэтгэх захирал |

## ХАРААТ БУС ГИШҮҮД:

| | | |
|---|---|---|
| **1** | **Г.Атармаа** | **“Өмгөөлөгчдийн холбоо”-д өмгөөлөгч”** |
| 2 | Л.Цэцгээ | Хайспийд ХХК, хэсгийн дарга |
| 3 | Л.Ганчимэг | МИАТ, ахлах хуульч |

# “ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ШИВЭЭ ОВОО ХК

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 100 дугаар, 2016 оны 68 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий нүүрсний уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг “Шивээ-Овоо” ХК-ийн төрийн эзэмшлийн төлөөллийг хангах, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 90 хувийн төлөөллийг бүрдүүлэн ажиллах үүргийг “Эрдэнэс Монгол” ХХК-д олгосон.

1995 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурлаар тус уурхайг Төрийн өмч давамгайлсан ”Шивээ-Овоо” ХК болгон өөрчлөн зохион байгуулж, компанийн дүрмийн сангийн 90 хувь нь төрийн өмчид үлдэж, 10 хувь нь 1500 гаруй хувьцаа эзэмшигчдэд хувьчлагдсан.

“Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 05 дугаар тогтоолоор шинэчлэгдэн байгуулагдаж, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээс 3 хараат бус гишүүн, төрийн мэдлийн 90 хувийн хувьцаа эзэмшигчийн зүгээс 5 гишүүн, жижиг хувьцаа эзэмшигчийн зүгээс 1 гишүүн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит хуралдаанаар улсын болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой бүх байгууллага, аж ахуйн нэгжийг он дуустал хэмнэлтийн горимд шилжүүлсэнтэй холбогдуулан 2021 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн батлагдсан төсвийн хүрээнд 63.7 хувийн зардлын гүйцэтгэлтэй буюу зардлыг тэвчих замаар батлагдсан төсвөө хэмнэж ажилласан. 2022 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг 30 хувиаар бууруулж төсөвлөсөн буюу 127.4 сая төгрөг баталсан. Батлагдсан төсвийн 83 хувь нь цалин, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал ба 17 хувь нь хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулахтай холбоотой зардал болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин нь Засгийн газрын 2016 оны өрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журамд заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй бөгөөд 2019 оноос хойш нэмэгдээгүй болно.

“Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон компанийн дүрмийн дагуу Хувьцаа эзэмшигчид, Гүйцэтгэх удирдлагын уялдаа холбоог хангаж, ирүүлсэн санал, асуудлуудыг цаг тухайд нь шийдвэрлэх, Гүйцэтгэх удирдлагын зөвлөмж, бэлтгэл ажлын дагуу компанийн жилийн санхүү, бизнес төлөвлөгөө гэх мэт компанийн стратеги, бизнесийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох ажлуудыг гүйцэтгэж байна.

Компанийн засаглал, ил тод байдлын хүрээнд ТУЗ-ийн нийт гишүүдийн гуравны нэгийг хараат бус гишүүд бүрдүүлж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны гаргасан дүрэм журмын дагуу мэдээллүүдийг цаг тухайд явуулж, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан мэдээллүүдийг олон нийтэд хүргэдэг.

Мөн Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, холбогдох яамдын гаргасан тогтоол, шийдвэрийг цаг тухайд нь хэрэгжүүлж ажиллаж байна.

Сангийн сайдын 2012 оны
... дугаар тушаалын
3 дугаар хавсралт

| Регистрийн дугаар: | 2 | 0 | 0 | 4 | 8 | 7 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|

Хаяг : Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг

Шуудангийн хаяг : Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг

Утас : 7054-6464 Факс : 7054-6464

Өмчийн хэлбэр : Төрийн 90 хувь, хувийн 10 хувь.

A

**“ШИВЭЭ-ОВОО” ХК**
**2021 ОНЫ 4 - Р УЛИРЛЫН**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

| Хянаж хүлээн авсан байгууллагын нэр | Сар, өдөр | Гарын үсэг |
|---|---|---|
| | | |
| | | |
| | | |
| | | |

**“ШИВЭЭ-ОВОО” ХК-ийн**

**2021 оны 4 –р улирлын санхүүгийн тайлангийн**

**бодит байдлын тухай мэдэгдэл**

2021 оны 12 сарын 31 өдөр

Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин , ерөнхий нягтлан бодогч Н.Энхжаргал бид манай аж ахуйн нэгжийн 2021 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 17.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ____ Ц.ЭНХТҮВШИН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ ____ Н.ЭНХЖАРГАЛ

Сангийн сайдын 2017 оны 361
дүгээр тушаалын 2 дугаар
хавсралт

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

**Шивээ Овоо ХК** **2021.01.01 - 2021.12.31**

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | 2021.01.01 | 2021.12.31 |
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 2,881,311,227.79 | 409,413,858.07 |
| 1.1.2 | Дансны авлага | 5,843,208,271.02 | 5,929,917,612.61 |
| 1.1.3 | Татвар, НДШ - ийн авлага | 0.00 | 0.00 |
| 1.1.4 | Бусад авлага | 188,654,163.75 | 337,141,659.70 |
| 1.1.5 | Найдваргүй авлагын хасагдуулга | -3,191,012,968.00 | -3,164,825,113.00 |
| 1.1.6 | Бараа материал | 16,903,451,136.03 | 16,829,574,285.68 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 5,880,137,749.44 | 2,869,615,048.52 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | 0.00 | 0.00 |
| 1.1.10 | Дуусаагүй үйлдвэрлэл | 0.00 | 0.00 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 28,505,749,580.03 | 23,210,837,351.59 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 61,594,328,702.56 | 64,900,040,306.76 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 189,628,430.36 | 189,628,430.36 |
| 1.2.3 | Хойшлогдсон хөрс хуулалтын шавхагдал | -2,674,133,497.20 | -2,674,133,497.20 |
